

Б.НАРАНТУЯА
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

201_ оны __ дугаар сарын __-ны өдөр

№

Улаанбаатар хот

2017 12 11 166

Энэхүү **АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ** (цаашид “Гэрээ” гэнэ)-г нэг талаас Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Бодлогын судалгаа, удирдлагын сургалтын албаны дарга Д.Баттулга (цаашид “Захиалагч” гэнэ), нөгөө талаас Чимэддамба овогтой Оюун /РД: ШВ64053002/ (цаашид “Ажил гүйцэтгэгч” гэнэ) (цаашид хамтад нь “Талууд”, тус тусад нь “Тал” гэнэ) нар Монгол улсын Иргэний хуулийн 343 дугаар зүйл болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журмыг удирдлага болгон дараах нөхцлийг харилцан тохиролцон байгуулав.

1.Нийтлэг заалт

1.1 Энэхүү гэрээгээр Ажил гүйцэтгэгч нь Захиалагчийн даалгаврын дагуу, “ДЭМБ-ын зөвлөх ФЕ ВИДА Н.ДИ-ЛИАЧО 2017 оны 12 дугаар сарын 11-ний өдрөөс 12 дугаар сарын 19-ний өдрүүдэд ЭМҮТ-ны багийн чадавхийг сайжруулах ажлын орчуулагчийн үүрэг гүйцэтгэх” ажлыг гүйцэтгэхэд гарах харилцааг зохицуулна.

1.2 Энэхүү гэрээнд зохицуулагдаагүй харилцааг Монгол Улсын Иргэний хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.

2.Гэрээний хугацаа

2.1 Энэхүү Гэрээ нь 2017 оны 12 дугаар сарын 11-ний өдрөөс 19-ний өдрийг дуустал 8 хоногийн хугацаатай байна.

2.2 Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас Ажил гүйцэтгэгч нь ажлыг хугацаанд нь гүйцэтгэж чадахгүйд хүрвэл Захиалагчид нэн даруй мэдэгдэж Захиалагч нь нэмэлт хугацаа тогтоож өгнө.

3. Ажил үйлчилгээний төлбөр

3.1 Гэрээгээр гүйцэтгэх ажлын үйлчилгээний төлбөр нийт 1200000 (Нэг сая хоёр зуун мянга) төгрөг байна. (Үүнд ХХОАТ, НДШ орсон болно).

3.2 Ажил гүйцэтгэгч нь гүйцэтгэвэл зохих нийт ажил үйлчилгээг бүрэн гүйцэтгэж Захиалагчид ажлын үр дүнг хүлээлгэн өгч тайлагнах бөгөөд Захиалагч ажлыг үр дүнг хүлээн авсанаас хойш ажлын 10 хоногийн дотор ажил үйлчилгээний төлбөрийг Ажил гүйцэтгэгчийн ХААН банкны 5007241829 тоот төгрөгийн дансанд шилжүүлнэ.

4. Захиалагчийн эрх, үүрэг

4.1 Ажил гүйцэтгэгчийг ажлын даалгавар болон шаардлагатай мэдээллээр хангах;

4.2 Гэрээнд заасан хугацаа болон ажлын үр дүнг хүлээн авмагц ажил үйлчилгээний төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөх;

4.3 Гүйцэтгэсэн ажлын үр дүнг гэрээнд заасан хугацаанд хүлээн авах;

4.4 Захиалагч нь ажлын үр дүнг хүлээн авсанаас хойших аливаа эрсдэлийг дангаар хариуцах;

4.5 Ажил гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн ажил, үүргээ зөрчиж ноцтой алдаа, дутагдал гаргасан болон хугацаа алдсан тохиолдолд Захиалагч нь энэхүү гэрээг нэг талын санаачлагаар цуцлах ба өөрт учирсан хохирлоо нөхөн төлүүлэх;

4.6 Захиалагч нь баталгаат хугацааны 1 сарын дотор ажлын үр дүнд доголдол илэрсэн тохиолдолд тухайн доголдолыг арилгуулахаар Ажил гүйцэтгүүлэгчээс шаардах;

4.7 Гүйцэтгэсэн ажлын үр дүн доголдолтой бол ажил гүйцэтгэгчийн зардлаар уг доголдлыг арилгуулах, эсхүл ажлыг шинээр гүйцэтгүүлэхээр шаардах.

5. Ажил гүйцэтгэгчийн эрх, үүрэг

5.1 Гэрээгээр хүлээсэн ажил, үүргийг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, стандартын дагуу мэргэжлийн өндөр түвшинд хийж гүйцэтгэн гэрээнд заасан хугацаанд нь Захиалагчид хүлээлгэн өгөх;

5.2 Гүйцэтгэсэн ажлын үр дүнг Захиалагчид хүлээлгэн өгөхөөс өмнө ажлын үр дүнд учирч болох эрсдэлийг дангаар хариуцах;

5.3 Гэрээгээр хүлээсэн ажил, үүргийг биечлэн гүйцэтгэх;

5.4 Дараахь тохиолдолд Захиалагчид нэн даруй мэдэгдэх үүрэгтэй:

- Ажил гүйцэтгүүлэхээр Захиалагчийн өгсөн зааварчилгаа, даалгавар нь ажлын чанар, үр дүнд муугаар нөлөөлөхөөр байвал;
- Ажлын чанар, үр дүнд муугаар нөлөөлөхөөр, ажил гүйцэтгэгчээс үл хамаарах ямар нэгэн нөхцөл байдал бий болсон.

5.5 Ажил гүйцэтгэгч нь энэхүү гэрээнд заасан үүргээ биелүүлээгүйгээс Захиалагч болон гуравдагч этгээдэд учирсан аливаа хохирлыг дангаар хариуцан арилгах;

5.6 Захиалагчийн өмчлөлд ямар нэгэн доголдолгүй үр дүн шилжүүлэх;

5.7 Ажлын үр дүн доголдолыг арилгахад шаардагдах зардлыг хариуцах;

5.8 Ажил гүйцэтгэгч нь ажил үйлчилгээний төлбөрийг гэрээнд заасаны дагуу шаардах;

5.9 Ажил үйлчилгээний даалгаварын талаарх аливаа мэдээллээр хангагдах.

6. Талуудын хүлээх хариуцлага

6.1. Талууд энэхүү гэрээнд заасан хугацаанд үүргээ гүйцэтгээгүй эсвэл зохих ёсоор гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй ажлын үнийн дүнгийн 0,1 хувьтай тэнцэх алданги төлнө.

6.2. Хэрэв талуудын хооронд маргаан гарвал талууд эвийн журмаар шийдвэрлэх ба маргаанаа шийдвэрлэж чадахгүйд хүрвэл шүүхээр шийдвэрлүүлнэ.

7. Бусад заалт

7.1. Талууд энэхүү гэрээнд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

7.2. Талууд Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

7.3. Гэрээний нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн бичгээр хийгдэж талууд гарын үсэг зурсанаар хүчин төгөлдөр болно.

7.4. Учруулсан хохирлыг арилгахтай холбогдсон асуудлаар 2 тал харилцан тохиролцож хууль, тогтоомжид заасан үндэслэлээр гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж болно.

Талууд

Захиалагчийг төлөөлж:

Гарын үсэг

Э.Баттуяа (Э.Баттуяа)

Хаяг

Увс сум III-р хороо

17 байр 19 тоот

Утас

99080321

/Тамга тэмдэг/

Ажил гүйцэтгэгч:

Гарын үсэг

Ч.Оюун /Оюун

Хаяг

Увс сум III-р хороо

61-9

Утас

99886416

/Тамга тэмдэг/